



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 359

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 94,600,000.00 (ерэн дөрвөн сая зургаан зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 39,266,417.68 (гучин есөн сая хоёр зуун жаран зургаан мянга дөрвөн зуун арван долоон төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу Шүүхийн сахилгын хороонд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

- 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;
- 2.3. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт



"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Шүүхийн сахилгын хороонд
 балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (өртөг)
1	Тоёота Ланд круйзер-200, 63-86 УНИ улсын дугаар, JTMDV09J694038711 арлын дугаар	2009/2010	1	Ш	94,600,000.00	39,266,417.68	55,333,582.32
Нийт дүн						(гучин есөн сая хоёр зуун жаран зургаан мянга дөрвөн зуун арван долоон төгрөг жаран найман мөнгө)	(тавин таван сая гурван зуун гучин гурван мянга таван зуун наян хоёр төгрөг гучин хоёр мөнгө)